



Захиалагч

Хэнтий айгийн
засаг даргын
тамгын газар



Гүйцэтгэгч

“Засмал зам”
ХХК

Зургийн шифр-23/22

ТАЙБАР БИЧИГ

ТӨВ ЦЭНГЭЛДЭХИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ХОЙД ТАЛЫН АВТО ЗАМЫН
ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2022 он



Захиалагч

Хэнтий айгийн
засаг даргын
тамгын газар



Гүйцэтгэгч

“Засмал зам”
ХХК

Зургийн шифр-23/22

ТАЙБАР БИЧИГ

ТӨВ ЦЭНГЭЛДЭХИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ХОЙД ТАЛЫН АВТО ЗАМЫН
ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

Захирал



Н.Нямсүрэн

Зургийн инженер

Б.Пүрэвсүрэн



Улаанбаатар хот
2022 он

Гарчиг

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
1.1 Зураг төсөл зохиох үндэслэл	3
1.2 Ажлын бүтэц, бүрэлдэхүүн.....	4
1.3 Төслийн танилцуулга	5
БҮЛЭГ 2. ТРАССЫН СУДАЛГАА	6
2.1 Төлөвлөж буй авто замын өнөөгийн нөхцөл байдал	6
2.2 Талбайн хайгуул байр зүйн судалгаа	6
2.3 Тэнхлэгийн координат	7
БҮЛЭГ-3. АВТО ЗАМЫН ТӨСӨЛЛӨЛТ	9
3.1 Авто замын техникийн хамшийн үзүүлэлтүүдийн жагсаалт	9
3.2 Зураг төслийн ажлын хүрээнд хийсэн ажлууд	9
3.3 Төсөллөлтийн стандарт, норм дүрэм	10
3.4 Авто замын зураг төсөвт тусгасан зүйл	11
3.5 Зогсоолын зураг төсөвт тусгасан зүйл.....	11
3.6 Дугуйн замын зураг төсөвт тусгасан зүйл.....	12
БҮЛЭГ-4. ХУЧИЛТЫН ТООЦОО.....	20
4.1 Хучилтын тооцооны аргачлал	20
4.2 Хучилтын бүтээцийн төлөвлөлт.....	20
4.3 Тооцоонд ашигласан үзүүлэлтүүд.....	21
4.4 Хучилтын дээрх тооцоот ачаалал тодорхойлох	21
4.5 Уян харимхайн хотойлтын тооцоо.....	22
4.6 Гулсалтын эсрэг тогтворын тооцоо.....	22
4.7 Гулзайлтын үеийн эсэргүүцлийн тооцоо.....	23
БҮЛЭГ 5 УС ЗҮЙН ТООЦОО	25
5.1 Ус хураах талбай	25
5.2 Авто замын уур амьсгалын нөхцөл	26
5.3 Зарцуулгын тооцооллын аргачлал	27
5.4 Хоногийн хамгийн их тунадас түүний хангамшил	27
5.5 ЗАРЦУУЛГЫН ТООЦОО	28

5.5.1 Томьёоны өгөгдөл	28
2 Зарцуулгын тооцоо.....	30
5.5.3 Өгөгдөл.....	30
5.6 ӨНГӨРҮҮЛЭХ ЧАДВАРЫН ТООЦОО	31
5.6.1 $\Phi=500$ хоолойн өнгөрүүлэх чадвар.....	31
5.7 U БЕТОН ШУУДУУ БАЙРЛУУЛАХ ТООЦОО	32
БҮЛЭГ 6 ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА	34
ХАВСРАЛТ 1 УС ЗҮЙН ТООЦОО.....	37
ХАВСРАЛТ	41
ЗУРГИЙН ДААЛГАВАР.....	42

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Зураг төсөл зохиох үндэслэл

Хэнтий аймгийн ЗДТГ-н дугаар № 3Т -2022/24 дугаартай зураг төсөл боловруулах гэрээ болон Хэнтий аймгийн засаг даргын орлогч Л.Батсайханы 2022оны 09 дүгээр сарын 23 –ний өдөр баталсан Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хойд талын авто замын нарийвчилсан зураг төсөл боловруулах ЗД-2022/069 дугаартай зургийн болон дараах бичиг баримтуудыг үндэслэн боловсруулав.

Үүнд:

1. “Фулл роуд ” ХХК-д гүйцэтгэсэн инженер геодезийн хэмжилт
2. “Ган хошуу” ХХК-д гүйцэтгэсэн инженер геологийн судалгааны тайлан
3. Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016
4. Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт БНБД 30-01-04
5. Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНБД 32-02-12
6. Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага MNS6808:2019
7. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004
8. Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗХТ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэнэ.

Зураг төслийн ажлын гүйцэтгэгчээр тус байгууллага ажилласан бөгөөд туслан гүйцэтгэгчээр дараах байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан болно.

Үүнд:

1. Инженер геологийн судалгааны ажлыг "Ган хошуу" ХХК-д гүйцэтгэж тайлан гарч магадлалаар баталгаажсан.
2. Авто замын дагуу байрлуулах гэрэлтүүлгийн ажил болон цахилгаан дамжуулах шугам сүлжээг хамгаалах, ажлыг "Ариун мөнхийн гэрэл" ХХК-д гүйцэтгэж ажлын зураг, төсөв гарч магадлалаар баталгаажсан.

1.2 Ажлын бүтэц, бүрэлдэхүүн

- Геодезийн 1:500-ны масштабтай байр зүйн зураг, ажлын тайлан
- Геологийн хайгуул судалгааны материал, инженер-геологийн тайлан
- Авто замын төлөвлөлтийн шатанд буюу авто замын дэвсгэр зургийг боловсруулж дараах албан байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөл боловсруулна.

Үүнд:

Батлав:

1. Хэнтий аймгийн ерөнхий архитектор

Зөвшилцсөн

2. Хэнтий аймгийн ХО,ХБТХ
 3. Хэнтий аймгийн, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
 4. “Хэнтий ус” ОНӨАТҮГ
 5. Хэнтий аймгийн “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК
 6. “БЗӨБЦТС” ТӨХК-ийн Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбар
 7. Хэнтий аймгийн Замын цагдаагийн тасаг
 8. Хэнтий аймгийн Онцгой байдлын газар
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл
 - Тайлбар бичиг
 - Техникийн шаардлага
 - Зам барилгын ажлын төсөв

1.3 Төслийн танилцуулга

- Төслийн захиалагч байгууллага: Хэнтий аймгийн ЗДТГ
- Төслийн байршил, нэр: Хэнтий аймаг, Хэрлэн сум Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хойд талын авто зам
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр: Орон нутгийн сан
- Авто замын техникийн ангилал, замын зэрэг: Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
- Замын хучилтын хийц: Хучилтын бүтээцийн тооцоогоор үндэслэнэ
- Зураг төсөл зохиох үе шат, хугацаа: 1 үе шаттай 2022 он
- Зураг төслийн байгууллага: “Засмал Зам” ХХК (Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага)
- Зургийн төсөл хариуцсан инженер: Б.Пүрэвсүрэн -80708181
- Зураг төслийг боловсруулахад оролцсон туслан гүйцэтгэгч байгууллагууд:
 - Цахилгаан гэрэлтүүлгийн зураг төсөл “Ариун мөнхийн гэрэл” ХХК
 - Барилгын инженер-геологийн “Тан хошуу” ХХК
- Байршил: Хэнтий аймгийн Хэрлэн сум Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хойд талын зам



Зураг-1, Авто замын байршлыг зураг

БҮЛЭГ 2. ТРАССЫН СУДАЛГАА

2.1 Төлөвлөж буй авто замын өнөөгийн нөхцөл байдал

Одоо байгаа авто замын нөхцөл байдлын судалгааны ажлын хүрээнд дараах ажлыг хийсэн.

2.2 Талбайн хайгуул байр зүйн судалгаа

ЗД – 2022/069 дугаартай зураг төсөл боловсруулах даалгаварт өгсөн трассын тэнхлэгийн дагууд талбайн хагуул судалгаа хийсэн. Замын эхлэл, эргэлтийн өнцөг, замын төгсгөл зэрэг онцлог цэгийн байршлыг газар дээр нь бодитоор шалган туслан гүйцэтгэгч байгууллагуудын ажлыг эхлүүлсэн.



Зураг-2, I Хэсгийн одоогийн нөхцөл байдлын зураг



Зураг-3, II Хэсгийн одоогийн нөхцөл байдлын зураг



Зураг-4, I Хэсгийн одоогийн нөхцөл байдлын зураг

2.3 Тэнхлэгийн координат

Зам I хэсэг

Зай, км	X, м	Y, м
---------	------	------

0+000.000	5240410.635	474026.286
0+020.000	5240418.798	474044.544
0+040.000	5240426.961	474062.803
0+060.000	5240435.124	474081.061
0+080.000	5240442.829	474099.509
0+100.000	5240448.207	474118.757
0+120.000	5240451.774	474138.436
0+140.000	5240455.276	474158.127
0+160.000	5240458.778	474177.818
0+180.000	5240462.279	474197.509
0+200.000	5240465.781	474217.2
0+220.000	5240469.282	474236.891
0+240.000	5240472.784	474256.582
0+260.000	5240476.286	474276.273
0+280.000	5240479.787	474295.964
0+300.000	5240483.289	474315.656
0+320.000	5240486.791	474335.347
0+340.000	5240490.292	474355.038
0+360.000	5240493.794	474374.729
0+380.000	5240497.296	474394.42
0+400.000	5240500.797	474414.111
0+420.000	5240504.299	474433.802
0+440.000	5240507.801	474453.493
0+460.000	5240511.302	474473.184
0+480.000	5240514.804	474492.875
0+500.000	5240518.306	474512.566
0+520.000	5240521.947	474532.231
0+540.000	5240526.887	474551.606
0+560.000	5240533.361	474570.523
0+580.000	5240541.029	474588.994

Зам II хэсэг

Зай, км	X, м	Y, м
0+000.000	5240513.393	474584.334
0+020.000	5240532.415	474578.154
0+040.000	5240551.436	474571.975
0+060.000	5240570.464	474565.816
0+080.000	5240589.764	474560.595
0+100.000	5240609.297	474556.3
0+120.000	5240628.834	474552.023
0+127.283	5240635.949	474550.466

БҮЛЭГ-3. АВТО ЗАМЫН ТӨСӨЛЛӨЛТ

3.1 Авто замын техникийн хамшийн үзүүлэлтүүдийн жагсаалт

№	Үзүүлэлтүүд	Х/нэгж	Хэмжээ
1	Замын зэрэг		Туслах гудамж зам
2	Замын урт	км	0.716
3	Тойруугийн тоо	ш	3
4	Хэвтээ муруйн хамгийн бага радиус	м	150
5	Хэвтээ муруйн хамгийн их радиус	м	250
6	Тойруугийн нийт урт	м	574
7	Тойруугийн трассанд эзлэх хувь	%	80
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	8500
9	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	12300
10	Дагуугийн хамгийн их налуу	%	5.1
11	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	81.8
12	Явган хүний замын өргөн	м	1.5-2.5
13	Замын хөндлөн налуу	%	2
14	Гарцны хамгийн бага радиус	м	6
15	Явган хүний замын хөндлөн налуу	%	2
16	Замын далангийн өргөн	м	15.5-53.7
17	Зорчих хэсгийн өргөн	м	7.5-11
18	Замын эгнээний тоо	ш	2-3
19	Хөвөөний өргөн	м	0.5
20	Өндөрлөгөөний хажуу налуу	-	m=1:1.5
21	Ухмалын хажуу налуу	-	m=1:1.5
22	Хучлагын төрөл		Асфальтбетон
23	Хучилтын бүтээц		Асфальт бетон хучлага өнгө үе-3 см Асфальт бетон хучлага суурь үе-4 см Буталсан чулуун суурь -20 см Суурийн доод үе-30 см
24	Хөдөлгөөний тооцоот хурд	Км/цаг	60

3.2 Зураг төслийн ажлын хүрээнд хийсэн ажлууд

Зураг төслийг боловсруулахдаа Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль дүрэм норм стандартыг баримтлалаа.

Зөвлөхийн үйлчилгээний хүрээнд дараах ажлуудыг дарааллын дагуу гүйцэтгэлээ

- Замын үндсэн байрлалыг тодорхойлж урьдчилсан дэвсгэр зураг гаргаж захиалагчтай зөвшилцлөө.
- Захиалагчтай зөвшилцсөн дэвсгэр зургийн дагуу байр зүйн судалгаа, геодезийн хэмжилтийн ажлуудыг хийсэн.
- Холбогдох шугам сүлжээний байгууллагуудтай зөвшилцсөний дараа ажлын зургийг захиалагчаар батлуулсан болно.
- Замын тэмдэг, тэмдэглэгээ, замын тоноглолын ажлуудыг нарийвчилсан зураг төсөлд тусгаж замын цагдаатай зөвшилцсөн.
- Ажлын тоо хэмжээ, төсвийн тооцоог гаргалаа.

3.3 Төсөллөлтийн стандарт, норм дүрэм

Авто замын зураг төслийн ажлыг гүйцэтгэхдээ дараах норм дүрэм, стандарт, техникийн шаардлагуудыг баримтлана.

- Авто зам төсөллөх норм дүрэм ЗЗБНБД 22-004- 2016
- Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04
- Замын тэмдэглэл (Техникийн ерөнхий шаардлага) MNS 4759:2014
- Замын тэмдэг (Техникийн ерөнхий шаардлага) MNS 4597:2014
- АЗУГН 2.01.01-2004
- Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНБД 32-02-12
- Монгол орны асфалтбетон хучлагатай авто замын хучилтын хийцийн жишиг цомог
- Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага ЗЗБНБД 31-008-2016

3.4 Авто замын зураг төсөвт тусгасан зүйл

Авто замын төлөвлөлтийг дараах байдлаар гүйцэтгэлээ.

Үүнд:

- Одоо хийгдэж байгаа явган хүний зам талбайтай өндөржилт болон байрлалын хувьд уялдаж байхаар зураг төслийг хийж гүйцэтгэлээ.
- Ус зүйн тооцооны үндсэн дээр орчны хамгийн нам цэг болох км 0+480.0 ф=500*2 хос төмөрбетон хоолойг хийхээр зураг төсөвт тусгаж өгөв.
- Тус авто зам нь 2 талдаа 1 м – 3 м өргөнтэй ногоон байгууламж, мөн 2 талдаа 1.5 м өргөнтэй явган зам, зорчих хэсгийн зүүн талд 2.0 м өргөнтэй дугуйн замтай төлөвлөлөө. Дугуйн зам явган зам хоёр зэрэгцэж явахаар тусгаж цагаан шугамаар тусгаарлаж өглөө.
- Авто замын зорчих хэсгийн хөндлөн хэвгийг төлөвлөхдөө зорчих хэсгийн ус хэвгийгээр чөлөөтэй урсан зайлж байхыг бодолцон баруун тал руу 1.5 хувийн налуутай байхаар төлөвлөлөө.
- Хашлаганы L хэлбэрийн бетон суурийг В30 маркийн бетоныг бетон зуурмагийн үйлдвэрээс авч хийхээр тусгаж өгсөн.
- Явган хүний гарцтай хэсэгт гарцны хашлага хийж өгөхөөр оруулж өгсөн.

3.5 Зогсоолын зураг төсөвт тусгасан зүйл

- Хэвтээ төлөвлөлтийг норм дүрэм ЗЗБНБД 22-004-2016 дагуу боловсрууллаа.
- Дагуу төлөвлөлтийг гудамж замын хамгийн бага налуугийн шаардлагыг хангаж байхаар төлөвлөлөө.
- Зогсоолыг хүртээмжтэй байлгахыг зорьж төлөвлөлөө.
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар норм дүрмийн дагуу зогсоол төлөвлөлөө.
- Зогсоолын зорчих хэсгийн хөндлөн хэвгийг төлөвлөхдөө зорчих хэсгийн ус хэвгийгээр чөлөөтэй урсан зайлж байхыг бодолцон зүүн тал руу 1.5 хувийн налуутай байхаар төлөвлөлөө.
- Зогсоол хэсгийн ус хаагдах газруудад ус зайлуулах цорго төлөвлөж ажлын тоо хэмжээг төсөвт тусгалаа.

3.6 Дугуйн замын зураг төсөвт тусгасан зүйл

- Дугуйн замын хучилтын хийцийг 2 янзаар төлөвлөлөө. Автомашины гарцтай хэсгүүдэд дугуйн замын гарцны тэмдэглэгээгээр тэмдэглэж, асфальт бетон хучилтын зузааныг 5см байхаар төлөвлөлөө.
- Мөн автомашины гарцны 2 талд автомашиныг дугуйн замаар зорчуулахгүй байхыг бодолцон дохионы шонг төлөвлөлөө.

3.7 Зам барилгын ажлын төсвийн тооцоо, ашиглалтын үеийн засвар арчлалт, үр ашиг

- Төсвийн тооцоог Зургийн инженерийн тодорхойлсон ажлын тоо хэмжээг үндэслэн, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7-дугаар сарын 31-ний өдрийн 256-дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНБД 81-013-2019” –ын дагуу төсөв зохиох компьютерийн RBC-Estimator программ ашиглан гүйцэтгэлээ.
- Зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын тарифт цалинг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07-р сарын 31-ий өдрийн 256-р тушаалын дагуу тооцлоо.
- Зам барилгын ажлын механизмын операторчидын цалинг машин механизмын зардалын дүнгээс 8.7 %-иар бодож төсөвт тусгах ба нэгдсэн төсвийн тооцоонд машин механизмын зардалын дүнгээс хасаж тооцно.Тээврийн жолоочийн цалинг мөн үүний адил тооцно.
- Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 зүйлд заасны дагуу ажил олгогч /компани/-ийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зам барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер, техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 11.5 %-иар, Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын дагуу “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал”-ын шимтгэлийн хувь хэмжээг 3%-иар /нийтдээ 14.5 %/ тус тус тооцож, төсөв зохиов.
- ЗТАЖ-ын сайдын 2007 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн 187 тоот тушаалын дагуу удирдлагын зардлыг нийт цалингийн сангийн 63.5%-иар, ашгийн хэмжээг цалингийн сангийн 71.8%-иар бодож тооцлоо.
- Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг Зам Тээврийн Хөгжлийн яамны сайдын 2017 оны 10 сарын 13-ы өдрийн 212 тоот тушаалаар батлагдсан машин механизмын нэг машин цагийн жишиг нормын дагуу, Авто


машинаар ачаа тээвэрлэх зардлыг ЗТАЖ-ын сайдын 2008 оны 09 дугаар сарын 08-ны өдрийн 136 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифын дагуу, тус тус тооцов.

- Захиалагчийн хяналтын зардлыг барилга угсралтын ажлын нийт өртөгийн 2%, Магадлашгүй ажлын зардлыг шууд зардалын 2%, Нэмэгдсэн өртгийн албан татварыг “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” Монгол улсын хуулийн 11-р зүйлийн 11.1-р заалтын дагуу барилга угсралтын ажлынз ардлын 10%-иар тооцож төсөвт тусгалаа.
- Хөдөлмөрийн багаж хэрэгсэл, ажлын хувцасны элэгдэлийн зардлыг ЗТБХБЯ-ын сайдын 2012 оны 181-р тушаалын дагуу нийт цалингийн дүнгийн 13.6 %-иар тооцлоо.
- Норм нормативын зардалыг Авто замын тухай хуулийн 8.4.1-д заасны дагуу барилга угсралтын ажлын дүнгийн 0.4%-иар тус тус тооцлоо
- Зам барилгын үеийн ашиглалтын үеийн засвар арчлалтыг зам барилга ашиглалтад орж улсын комисст хүлээлгэн өгч гэрчилгээ гарснаар тухайн орон нутгийн зам засвар арчлалтын байгууллага хариуцах болно.
- Нийгэм эдийн засгийн үр ашиг нь тухайн бүсийг аялал зугаалгын бүс болгож байгаатай холбогдуулан тус авто замын төслийг хэрэгжүүлж байгаа болно.


3.8 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар авсан арга хэмжээнүүд

Уг ажлын хүрээнд хурд сааруулагч, авто замын тэмдэг, тэмдэглэл зэргийг хийж гүйцэтгэн, гарч болзошгүй зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлж төлөвлөв.

Замын хөдөлгөөний норм дүрмийн дагуу төлөвлөв.










Зураг-1: ПК 0 + 000.00 – ПК 0 + 330.00




Зураг-2: ПК 0 + 330.00 – ПК 0 + 716.64

Замын тоноглолд жолооч, зорчигчдыг мэдээлэл зааварчилгаар ханган замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, аваарийг бууруулж тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлыг сайжруулах зорилгоор төлөвлөгдсөн тоноглолууд багтана.

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах үүднээс дараах тэмдгүүдийг оруулж өглөө.

№	Тэмдэг	Тэмдгийн зориулалт
1		Явган хүний гарц /бүх гарц дээр/
2		Авто машины зогсоол /зосоолууд дээр/
3		Хурд сааруулагч /км 0+200, км 0+450 дээр/
4		Гол зам
5		Эгнээний эхлэл
6		Зам тавьж өгнө
7		Унадаг дугуйн зам



- Хурд сааруулагч, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлахаар зорчих хэсэгт байрлуулсан хурд сааруулагчийг төлөвлөх, суурилуулах, ашиглах







Замын тэмдгийг дараахь ангилалын дагуу хийнэ.







- i. Анхааруулах тэмдэг (Ж нь: “Өмнө огцом эргэлт” тэмдэг)
- ii. Заавал биелүүлэх тэмдэг (Ж нь: “Зогс” тэмдэг) (Зохицуулах болон Хориглосон тэмдгийг оролцуулан)
- ii. Стандартын мэдээллийн тэмдгүүд (Ж нь: Явган хүний гарц,)


Үндсэн ангилал тус бүрт Монгол улсын стандарт MNS 4597-2014-д заасан тэмдгийн янз бүрийн төрлүүд багтана. Тэмдгийн нүүр талыг гэрэл ойлгогчтой будгаар будаж Монгол улсын стандарт MNS 4597-2014-д зөвлөснөөр хэмжээ болон таних тэмдэг, тайлбарыг хийнэ. Хашлагатай 7.0 м өргөн асфальтан хучилттай зам барих тохиолдолд зөвхөн тэнхлэгийн шугам хийнэ. Замын тэмдэглэгээг Монгол улсын стандарт MNS 4759-2014-д заасанчлан хийнэ. Замын тэмдэглэгээг замын термопластик материалаар хийнэ. Төслийн замын дагуу төсөллөгдсөн тэмдэг, тэмдэглэгээг зураг тус бүрт нь тодорхой тусгаж харуулсан.

Дохионы шонд тавигдах шаардлагыг MNS 4596 : 2014 стандартын заалтыг үндэслэн тооцоолсон бөгөөд энэ нь нэг маягийн зурагт үзүүлсэний дагуу байх ба байршил, тоо хэмжээг хүснэгтээр зургийн ботид тусгасан байгаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах үүднээс дараах тэмдэглэлүүдийг оруулж өглөө.

№	Тэмдэглэл	Тэмдлэлийн зориулалт
1		<p>1.13а. Явган хүний зохицуулдаггүй гарц</p> <p>P=3 м</p>
2		<p>1.13б. Явган хүний гарц</p> <p>P=6 м</p>
3		<p>11. Зогс шугам гэрэл буюу зохицуулагчийн хориглосон дохио, эсвэл 3.5 "зогсохгүй явах хориотой" тэмдгийн заалтыг биелүүлэхийн тулд тээврийн хэрэгсэл зогсох газрыг заах</p>
4		<p>1.17 "Чиг заагч сум" тухайн эгнээнээс уулзвар нэвтрэх зөвшөөрсөн чигийг заах</p>
5		<p>1.1. Хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах -зам бүрийн урт нь 20м ээс багагүй байна</p>
6		<p>1.5. Хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах $V < 60 \text{ Km/h}$, $L1 = 1,000$ $L2 = 3,000$ $L1:L2 = 1:3$</p>

7		<p>1.6. Үргэлжилсэн дагуу шугаман тэмдэглэлд ойртож байгааг тэмдэглэх зам бүрийн урт нь 50м ээс багагүй байна $V < 60 \text{Km/h}$, $L1 = 3,000$ $L2 = 1,000$ $L1:L2 = 3:1$</p>
8		<p>1.7. Уулзвар дээрх хөдөлгөөний эгнээг тэмдэглэх $L1 = 500$; $L2 = 500$</p>
9		<p>1.14 Унадаг дугуйн зам буюу эгнээ зорчих хэсэгтэй огтлолцсон бэлчрийг тэмдэглэх.</p>
10		<p>Дугуйн замын тэнхлэгийн болон захын тэмдэглэл</p>
11		<p>4.4 Тэмдгийн хуулбар тэмдэглэл дугуйн зам</p>
		<p>7.15 Тэмдгийн хуулбар тэмдэглэл тулгуур эрхтэний бэрхшээлтэй иргэн</p>



Авто замын зураг төслийн
“Засмал Зам” ХХК

БҮЛЭГ 4 ХУЧИЛТЫН ТООЦОО

Улаанбаатар хот 2022 он

БҮЛЭГ-4. ХУЧИЛТЫН ТООЦОО

4.1 Хучилтын тооцооны аргачлал

Авто замын хучилтын тооцоог ОХУ-ын үндэсний стандарт авто замын уян хучилт төсөллөх ПНСТ 265-2018-ий дагуу тооцооны индорпавемент программ ашиглан гүйцэтгэлээ. Хучилтын хийцийн төсөллөлт нь доорх 2 дараалсан шатанд гүйцэтгэгдэнэ.

1. Хучилтын хийцийг төлөвлөх
2. Бат бэхийн тооцоо хийх

Бат бэхийн тооцооны шалгуур үзүүлэлт болох бат бэхийн коэффициентийг замын ангилал, хучилтын төрөл, найдваржилтын коэффициент болон тооцооны зорилгоос хамаарч хүснэгтээс авна

4.2 Хучилтын бүтээцийн төлөвлөлт

№	Хучилтын бүтээц	Хучилтын материал	Үеүдийн зузаан
1		Асфальтбетон хучлага өнгө үе	3 см
2		Асфальтбетон хучлага суурь үе	4 см
3		Буталсан чулуун суурь	20 см
4		Суурийн доод үе	30 см
Нийт хучилтын зузаан			57 см

4.3 Тооцоонд ашигласан үзүүлэлтүүд

Тооцоонд ашигласан үзүүлэлтүүд		Үзүүлэлтүүд
1	Хийсэн тооцоонууд	Хучилтын дээрх тооцоот ачаалал
2		Уян харимхайн хотойлт
3		Гулсалт
4		Гулзайлт
1.Цаг уурын мэдээлэл		
1	Бүс нутаг	Хэнтий аймаг Хэрлэн сум
2	Зам цаг уурын бүс	II B
3	Газрын гадарга	Хээрийн бүс
4	Цаг агаарын таагүй өдрүүдийн тоо	125
5	Хөрсний нягтруулалтын итгэлцүүр	1.02
6	Хөдөлтийн гүн	2.5-3.2 м
7	Дундаж температур	-2.8
8	Хөрсний тооцоот чийг W_p	0.74
2.Авто замын өгөгдлүүд		
1	Замын зэрэг	Нутаг дэвсгэрийн зам
2	Зурвасын тоо	2
3	Тооцоонд ашиглах зурвасын дугаар	1
4	Замын хучилтын төрөл	Капитал
5	Ашиглалтын тооцоот хугацаа Тсл	15 жил
6	Найдвар байдал итгэлцүүр K_p	0.95
7	Зурвасын өргөн	3.5 м
8	Ул хөрс	Шавранцар хөрс
9	Нягтралын коэфф	0.98
10	Тооцоот чийглэг	0.42
3. Тээврийн хэрэгсэлийн ачаалал		
1	Хөдөлгөөний эрчим	410 маш/хоног
2	Хөдөлгөөний эрчим өсөлт	4 %
3	Нэг тэнхлэг дээрхи тооцоот ачаалал	110 кН
4	Дугуйн даралт	0.6 МПа
5	Дугуйн мөр D (дин.)	39 см

4.4 Хучилтын дээрх тооцоот ачаалал тодорхойлох

Хөдөлгөөний эрчмийн тооллого

№	Тооллого хийсэн цэгийн байршил, км	Эгнээ зурвасын тоо	Хоногийн дундаж хөдөлгөөний эрчим, маш/хон						Нийт
			Хөнгөн тэрэг	Автобус	Ачааны авто машин				
					Даац, тн				
					5тн хүртэл	5-12	12-20	20 тн-оос дээш	
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	КМ 0.300	2	328	0	58	24	-	-	410

Нийлбэрийн коэффициентийг дараах томъёогоор олно

$$K_c = \frac{q^{T_{ca}} - 1}{q - 1} = \frac{1.04^{15} - 1}{1.04 - 1} \approx 20.02$$

Ашиглалтын хугацаанд үйлчлэх нийт ачаалалыг дараах томъёогоор олно

$$\sum N_p = 0.7 \times f_{пол} \times N_1 \times K_c \times T_{раг} \times k_n = 0.7 \times 1 \times 20 \times 20.02 \times 125 \times 1.31 = 45895.9$$

Шаардагдах уян харимхайн модулийг дараах томъёогоор олно

$$E_{тр} = \sqrt{\frac{p}{0.6}} \times 98.65 \times (\lg \sum N_p - c) = \sqrt{\frac{0.6}{0.6}} \times 98.65 \times (\lg 110000 - 3.25) \approx 176.72$$

4.5 Уян харимхайн хотойлтын тооцоо

Гадаргуугийн уян харимхайн модуль $E_{пов} = 200.74$ МПа

Бат бэхийн тооцоолсон итгэлцүүр $K_{расч} = 1.34$

Бат бэхийн шаардлагатай итгэлцүүр $K_{тр} = 1.17$

Бат бэхийн нөөц $(K_{расч} - K_{тр}) / K_{тр} \times 100\% = 14.53\%$ (Хангалттай байна.)

$$K_{расч} = \frac{E_{пов}}{E_{тр}} = \frac{200.74}{150} = 1.34; \quad \frac{K_{расч} - K_{тр}}{K_{тр}} \times 100\% = \frac{1.34 - 1.17}{1.17} \times 100\% = 14.53\%$$

4.6 Гулсалтын эсрэг тогтворын тооцоо

Ул хөрс: Шавранцар ул хөрс

Ул хөрсний уян харимхайн модуль-50 МПа

Дотоод үрэлтийн өнцөг $\varphi = 21^\circ$

Барьцалдах хүч $C_n = 0.024$ МПа Итгэлцүүр $K_d = 1.0$

Бат бэхийн тооцоолсон итгэлцүүр $K_{расч} = 2.17$

$$K_{расч} = \frac{T_{тр}}{T} = \frac{0.02795}{0.01291} = 2.17$$

Бат бэхийн шаардлагатай итгэлцүүр $K_{тр} = 1.000$

Бат бэхийн нөөц $(K_{расч}-K_{тр})/K_{тр} \cdot 100\% = 117\%$ (Хангалттай байна)

$$\frac{K_{расч} - K_{тр}}{K_{тр}} \times 100\% = \frac{2.17 - 1}{1} \times 100\% = 117\%$$

4.7 Гулзайлтын үеийн эсэргүүцлийн тооцоо

Материалын үзүүлэлтүүд

БНД 90/130 маркийн буюу үүнтэй ижил төсөөтэй битумээр зуурсан, I маркийн нягт, А төрлийн халуунаар дэвсэх асфальтбетон хольц

Хаврын нормативт эсэргүүцэл $R_0 = 9.5$ МПа Зэргийн цуцалтын үзүүлэлт $m = 4$

Ялгааны итгэлцүүр $\alpha = 6.3$

Бат бэхийн бууралтын итгэлцүүр $k_2 = 0.9$

Бат бэхийн тооцоолсон итгэлцүүр $K_{расч} = 1.33$

$$K_{расч} = \frac{R_n}{\sigma_r} = \frac{2.67}{2.012} = 1.33$$

Бат бэхийн шаардлагатай итгэлцүүр $K_{тр} = 1.000$

Бат бэхийн нөөц $(K_{расч}-K_{тр})/K_{тр} \cdot 100\% = 32.67\%$ (Хангалттай байна.)

$$\frac{K_{расч} - K_{тр}}{K_{тр}} \times 100\% = \frac{1.33 - 1}{1} \times 100\% = 32.67\%$$



*Авто замын зураг төслийн
“Засмал Зам” ХХК*

БҮЛЭГ 5 УС ЗҮЙН ТООЦОО

Улаанбаатар хот 2022 он

БҮЛЭГ 5 УС ЗҮЙН ТООЦОО

5.1 Ус хураах талбай

Хэнтий аймгийн Хэрлэн сумын төв замаас урд зүгт төлөвлөж буй авто замын хооронд дахь ус хураах талбай дээр усны зарцуулга болон төмөрбетон хоолойн өнгөрүүлэх чадварын тооцоог хийлээ.

№	Хоолойн байрлал	Ус хураах талбай (S) км ²	Жалгын налуу (%)	Энгэрийн налуу (%)	Жалгын урт, Км
1	0+480.0	0.2	1.4	1.8	0.567




Зураг 1, Ус хураах талбайн зураг

5.2 Авто замын уур амьсгалын нөхцөл

Авто зам барихаар төлөвлөж буй газар нутаг нь Монгол орны авто замын уур амьсгал-геотехникийн нөхцлийн II В буюу Хангай-Хэнтийн уул тайга ба Сэлэнгэ-Орхоны савын ойт хээрийн чийглэгдүү, нэн хүйтэн, хахир дэд бүсэд хамаарч байна.

Энэ бүсийн онцлог нь Авто замын уур амьсгалын мужлалаар Хангайн өндөр уулын нэн хүйтэн-чийглэгдүү байх уулт хээрийн хахир газрууд багтдаг. Мөн уур амьсгалын хүчтэй салхи шороон шуургатай, халуун бүгчим, хуурай онцлогтой. Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан, авто замын уур амьсгалын улирлын хөлдөлт-гэсэлттэй. Уулархаг хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, хөндий дагасан салхитай, хахир хүйтэн жаварлаг байх дэд бүсэд хамаарч байна.



Зураг 3

5.3 Зарцуулгын тооцооллын аргачлал

Хээрийн судалгааны явцад замын зурвасыг байр зүйн зурагт буулгаж, сайр жалгын огтолож байгаа цэгүүдийг байршуулж, ус хураах талбайн ерөнхий байдал /ургамалшилт, хөрсний бүтэц, ус хураах талбайн өргөн, урт болон голдирлын муруй, эргийн байдал зэрэг/-ын бичиглэл хийлээ.


Судалгаанд хамрагдаж байгаа замын ус хураах талбайн хэмжээ, дундаж өндөр, жалга болон хажуу бэлийн дундаж хэвгий болон сайр жалгын уртыг google earth –ийн гадаргууг ашиглаж тодорхойлж гаргав.

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт “Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм “/БНБД 2.01.14-86/ - с авлаа. Хур борооны үерийн их урсцын тооцоог гаргахын тулд хоногийн хамгийн их тунадасны хангамшлын тооцоог хийв.

5.4 Хоногийн хамгийн их тунадас түүний хангамшил

“Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд” /УЦУХ 1994 он/ хуудас136 зураг29)-д дурдсанаар хоногийн хамгийн их тунадасны 1%-ийн хангамж бүхий хэмжээг уг бүсэд $H_{1\%}=120$ мм гэж тодорхойлсныг цаашдын тооцоонд хамруулан хэрэглэв.

1%-ийн хангамж бүхий хоногийн хамгийн их тунадасны хэмжээний мужлал



Зураг 4 “ Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд”

/УЦУХ 1994 он/ хуудас 136, 29-р зураг

5.5 ЗАРЦУУЛГЫН ТООЦОО

200 км²-с бага ус хураах талбай бүхий гол горхи, сайруудын үерийн хамгийн их урсцын тооцоог (“Ус зүйн тодорхойлолтуудыг тооцох норм ба дүрэм” /БНБД 2.01.14-86./)-д заасны дагуу хур борооны эрчимжилтийн аргыг ашигласан болно. **200 км² – с бага** ус хураах талбайн усны зарцуулгыг III төрлийн дараах томъёогоор тооцно. /хязгаарын эрчмийн тооцоо/

$$Q_{p\%} = q'_{1\%} * \varphi * H_{1\%} * \delta * \lambda_{p\%} * A \text{ /Томьёо 1/}$$

Үүнд:

- $Q_{1\%}$ - Хамгийн их зарцуулга м³/сек
 - $q'_{1\%}$ - жилийн урсцын хэтрэх магадлалын хамгийн их модуль / м³/с * км² / хавсралт хүснэгт 1 – с авах
- φ - Урсцын хуримтлалын коэффициент / *Томьёо 2 – с* /
- $H_{1\%}$ - 1% хангамжийг давж гарах хоногийн хамгийн их тунадас, мм /Ойролцоох цаг уурын станцын өгөгдлөөр болон нормоос авна.
- δ -нууршил, ой, намагшилтын коэффициент
- $\lambda_{p\%}$ - 1 % ийн хангамшлаас P рүү шилжүүлэх коэффициент /хүснэгт -2 авах/
- A – Ус хураах талбай км²

5.5.1 Томьёоны өгөгдөл

1. $q'_{1\%}$ - хажуу энгэрээс ус урсан ирэх хугацаа болон жалгын хэлбэр зүйгээс хамааруулан / Φ_r /
Хавсралт хүснэгт 1-с авна.
2. Хажуу энгэрээр ус урсах хугацаа/ τ сек мин
 - Ойн бүсэд намагшил 20% -иас бага голд 60 мин
 - 20% -40% намагшилтай голд 100 мин
 - 40% -иас намагшилтай голд 150 мин
 - Ойт хээрийн бүсэд 60 мин
 - Хээр, говийн бүсэд 30 мин
 - Уулархаг нутагт 10 минутаар авна.
3. $\varphi = \frac{C_2}{(A+1)^{n3}} * \varphi_0 * \left(\frac{I_1}{5n}\right)^{n2}$ / *Томьёо 2* /

Үүнд:

- C_2 - Эмпириз коэффициент (ойн бүсэд 1.3, бусад бүсэд 1.2-оор авна)
- φ_0 - A=10 км² ус хураах талбайтай, дундаж налуу нь $I_B = 5\%$ бол $\varphi_0, n2$ –ийг хөрсний төрлөөс хамааруулан хавсралт хүснэгт 2 - с авна, $n3$ –ийг (ойн бүсэд 0.07, бусад бүсэд 0.11-оор авна)
- I_B – Хажуу энгэрийн дундаж хэвгийг

$$4. \Phi_r = (1000 * L) / (m_p * I_p^m * A^{1/4} * (\varphi * H_{1\%})^{1/4}) \text{ /Томьёо 3/}$$

Үүнд:

- Φ_r - Хажуу энгэрийн хэлбэр зүй
- L - Хажуу энгэрийн дундаж урт, км
- m_p - Голдирлын гадаргуун барзгаржилтын коэффициент /Хүснэгт 3-с /
- I_p - Голдирлын дундаж хэвгий %₀

$$5. \delta = 1 / (1 + C_o A_{oz}) \text{ /Томьёо 4/}$$

Харьцангуй нууршил A_{oz} -ын мэдээлэл байгаа тохиолдолд C_o -ын утгыг байгалийн бүх бүсэд 0.11-ээр, нууршлын дундаж жигнэсэн мэдээлэл A'_{oz} байгаа тохиолдолд C_o -ын утгыг ойн болон ойт хээрийн бүсэд 0.2-оор тал хээрийн бүсэд 0.4 –ээр тус тус авна.

2 Зарцуулгын тооцоо

№	Байрлал	A	$\theta'_{1\%}$	φ	H1%	δ	$\lambda_{\Gamma\%}$	$Q_{\Gamma\%}$	$Q_{2\%}$	$Q_{5\%}$	Хоолойн хэмжээ	Хоолойн налуу	Өнөөгүүлэх боломжит зарцуулга
		(км ²)	(м ³ /сек*км ²)					(м ³ /сек)	(м ³ /сек)	(м ³ /сек)	мм	%	(м ³ /сек)
